

ТӨСӨЛ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны дүгээр сарын-ны өдрийн
.... тоот тушаалын хавсралт

Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэн бүрийн сурч боловсрох эрх, тэгш хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх албан бус сургалтын хэлбэрийг “Боловсрол нөхөн олгох сургалт” гэнэ.

1.2. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр албан боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй иргэнд суурь боловсрол заавал олгох, бүх нийтийн ерөнхий боловсролыг нөхөн эзэмших, бие даан суралцах хүсэлтэй иргэдэд зориулан сургалт зохион байгуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Боловсрол нөхөн олгох сургалт (цаашид "сургалт" гэх)-ын агуулга, арга зүй, хэлбэр, хугацаа, үнэлгээ нь суралцагчдын боловсрол эзэмших хэрэгцээ, боломж, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн, олон хувилбартай, уян хатан, чөлөөтэй, нээлттэй, мэдээллийн технологид суурилсан байна.

1.4. Тодорхой шалтгааны улмаас албан боловсролд хамрагдаж чадаагүй, нэг ба түүнээс дээш жил завсардсан албан сургалтад хамрагдах боломжгүй иргэнийг боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн сургалтад хамруулна.

Хоёр. Сургалтын зохион байгуулалт

2.1. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засаг дарга захирамж гаргаснаар хуулийн этгээд (цаашид "сургалт зохион байгуулагч" гэх) боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулна.

2.2. Боловсрол нөхөн олгох сургалтыг аймаг, сум, дүүргийн ерөнхий боловсролын сургууль бүлгийн (танхимын, зайны, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалт, бие даах) сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

2.2.1. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад 2.2-т заасан бүлгийн хэлбэрээр сургалт зохион байгуулна;

2.2.2. Хилийн чанад дахь хэл соёлын ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад энэхүү журмын 3.4-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн зайны болон хосолсон хэлбэрийн сургалтад хамрагдана.

2.3. Сургалт зохион байгуулагч дараах шаардлагыг хангасан байна.

2.3.1. Сургалтын төлөвлөгөөг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө”-нд нийцүүлэн боловсруулсан байх;

2.3.2. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах байр танхим, тоног төхөөрөмж, өндөр хурдны интернэт, сургалтын хэрэглэгдэхүүн, бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн сургалтад ашиглах сурах бичиг, сургалтын модуль, шаардлагатай хэрэглэгдэхүүн, багшийн ном, гарын авлагаар хангагдсан байх;

2.3.3. Сургалт зохион байгуулах багш нь:

- багш мэргэжилтэй,
- боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн агуулга, холимог бүлгийн арга зүйн сургалтад хамрагдсан,
- зайны сургалт зохион байгуулах мэдээллийн технологийн мэдлэгтэй байх;

2.3.4. Сургалтын зохион байгуулалтын зардлыг нэг суралцагчид ногдох хувьсах зардлаас гадна орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр, хандив тусламж, хамтрагч байгууллагын дэмжлэг, бусад санхүүгийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байх;

2.4. Сургалт зохион байгуулагч нь боловсрол нөхөн эзэмших хүсэлтэй иргэний мэдлэг, чадварын түвшинг тогтоон зохих анги, түвшинд элсүүлнэ.

2.5. Хилийн чанадад суралцаж байгаад ирсэн суралцагчдаас энэхүү журмын 2.4-т заасны дагуу түвшин тогтоож боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журам, шийдвэрийг үндэслэн боловсрол нөхөн олгох сургалтад хамруулна.

2.6. Анги, насны зөрүүтэй суралцагчийг зохих түвшний агуулгын стандартыг хангасан тохиолдолд тухайн хичээлийн жилийн нэгдүгээр хагас жилд анги дэвшүүлэн суралцуулж болно.

2.7. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр холимог бүлгийн танхимын болон зайны сургалт зохион байгуулж байгаа багшийн долоо хоногт заах цагийн ачаалал 15 цаг хүртэл байж болно. Түүнээс дээш бол илүү цагт тооцно.

Гурав. Сургалтын баримт бичиг

3.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр”-ийг баримтална.

3.2. Боловсрол нөхөн олгох сургалтын төлөвлөгөөнд дараах агуулгыг тусган баталгаажуулсан байна. Үүнд:

3.2.1. Хичээлийн жилийн бүтэц, танхим, зайны болон бие даан хичээллэх сургалтын цагийн хэмжээ, хичээлийн хуваарь;

3.2.2. Багшлах боловсон хүчин, санхүүгийн нөөцийн хуваарилалт, тооцоо;

3.2.3. Боловсролын түвшин бүрээр судлах сурах бичиг, сургалтын модулийн төрөл, тоо;

3.2.4. Давтлага, шалгалтын хуваарь.

3.3. Сургалтын явцад дор дурдсан баримт бичгийг хөтөлнө. Үүнд:

- Багшийн журнал;
- Анги удирдсан багшийн дэвтэр;
- Суралцагчийн хувийн хэрэг;
- Суурь боловсролын гэрчилгээ;
- Бүрэн дунд боловсролын үнэмлэх.

3.4. Энэхүү журмын 2.4, 2.5-д заасны дагуу элссэн болон анги дэвшин суралцсан суралцагчийн үнэлгээ, хувийн хэргийг нөхөн бичиж (өмнөх ангиудын судлагдахуун бүрийн сурлагын үнэлгээг элсэн суралцахад авсан судлагдахуунуудын түвшин тогтоолтын үнэлгээ) холбогдох шийдвэрийг хавсарган баталгаажуулна.

Дөрөв. Сургалтын хэлбэр, хугацаа

4.1. Боловсрол нөхөн олгох танхимын сургалт жил бүрийн 9 дүгээр сарын 1, бусад хэлбэрийн сургалтын эхлэх хугацааг сургалт зохион байгуулагч нь суралцагчийн эрэлт хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан шийдвэрлэнэ.

4.2. Сургалт үргэлжлэх хугацааг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө”-ний 70-аас доошгүй хувьтай тэнцэхүйц байхаар төлөвлөнө.

4.3. Сургалтыг суралцагчийн мэдлэг, чадварын түвшин, суралцах боломжид үндэслэн танхимын, зайны, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалт, бие даах хэлбэрийн аль нэгээр, эсвэл эдгээр аргуудын хосолсон хэлбэрээр зохион байгуулах бөгөөд журмын 4.2-т заасан сургалтын хугацааг баримтална.

4.4. Суралцагч танхимаас бусад хэлбэрийн сургалтад хамрагдах гэрээ байгуулсан тохиолдолд жилд хоёроос доошгүй удаа, цугларалт бүрт хамгийн багадаа 14 хоног сургалтад хамрагдана.

4.5. Сургалтыг 10-аас доошгүй суралцагчтай холимог бүлэг байхаар зохион байгуулна.

4.6. Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах зөвшөөрлийг Боловсролын тухай болон бусад хууль тогтоомжид заасны дагуу олгоно.

Тав. Сургалтын явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

5.1. Сургалтын үйл ажиллагаанд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын ерөнхий газар, аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын газар тус тус хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллана.

5.2. Хамран сургалт, захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг бүх шатны Засаг дарга нар хүлээх бөгөөд сургалтын явц, чанар, үр дүн, хамрагдалтын талаар сургалт зохион байгуулагчаас гаргасан статистикийн мэдээг хянах чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тус тус гүйцэтгэнэ.

5.3. Сургалтын статистикийн мэдээг тогтоосон хугацаанд боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, Боловсролын ерөнхий газар болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.4. Суралцагчийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг сургалт зохион байгуулагч ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

5.5. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж, төгсөлтийн шалгалт өгөх суралцагчдын дэлгэрэнгүй мэдээллийг сургалт зохион байгуулагч, сургуулийн захиргаа боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн газраар дамжуулан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх ба төгсөлтийн шалгалт өгөх, боловсролын үнэмлэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг бага, дунд боловсролын төгсөлтийн шалгалтын журмаар зохицуулна.

Зургаа. Сургалтын санхүүжилт

6.1. Сургалтад хамрагдаж буй нэг суралцагчид ногдох нормативт зардлыг Засгийн газраас тогтоосон жишгийн дагуу улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6.2. Сургалт зохион байгуулахад суралцагчаас төлбөр авахгүй бөгөөд бага, суурь боловсролын сурах бичиг, сургалтын модулийг үнэ төлбөргүй ашиглуулна.

6.3. Энэхүү журмын 4.3-т заасан танхимын сургалтаас бусад хэлбэрийн сургалтыг зохион байгуулахад шаардагдах нэмэлт зардал (унаа, шатахуун, багшийн томилолт, урамшуулал, бусад зардал)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6.4. Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр, хандив тусламж, өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүжилтийн бусад эх үүсвэртэй байж болно.

---ooOoo---